



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

20 оны 12 сарын 28 өдөр

Дугаар 762

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын худалдаагаар
худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 4.2, 4.3 дахь заалт, “Мэдээ тайлангийн маягт батлах тухай” 269 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын харьяа Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсүүдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан, нийт 92,039,800.00 /өрэн хоёр сая гучин есөн мянга найман зуун/ төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий 3 ширхэг автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2.Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Дашдэмбэрэл, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсүүдийн дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу зохион байгуулах;

2.2.Дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4.Энэ тогтоолын биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримт, тээврийн хэрэгслийн улсын бүртгэлээс хасуулсан тодорхойлолтыг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТАЫН ХЭЛТСИЙН ДАРГА

1320163

Төрийн өмчийн бодлого, зорхицуулалтын газрын
2020 сны 12 дугаар сарын 28-ны өдрийн
762 дугаар тогтоолын хавсралт

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний өрөнхий газрын харяа
Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсүүдийн
үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нээлттэй дуудлагын
худалдаагаар худалдаах тээврийн хэрэгслийн жагсаалт

Д/д	Автомашины марк, улсын дугаар, арап	Нийтийн аралтад оцоо наадмын уулзажишийн хувь	Гүйлт, км (мянга)	Балансын үнэ, хуимтлайдсан элэгдэл (төгрөг)	Худалдах доод үнэ (төгрөг)	Балансад бүртгэлтэй байгаа байгууллага
1	Элентра, 09-52 УНК, арал № KMFХКС7АРТ U009040	2014/ 2014	231400	39,000,000.0	1,500,000.00	БЗД Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс
2	Портер, 81-93 ДУА, арал № KMFХКС7АРТ U009040	1996/ 2006	326800	4,639,800.0	500,000.00	Дундговь аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар
3	Лексус-470, 60-70 ОРО, арал № УЛJII00W364009711	2006/2006	526741	48,400,000.0	2,500,000.00	Орхон аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар
Нийт дүн				92,039,800.00 <i>/өрөн хоёр сая гучин есөн мянга наиман зуун/ мянган/</i>	4,500,000.00 <i>/дөрвөн сая таван зуун мянган/</i>	